

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2024/10

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.X	2023.X	2024.IX	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2024 оны 3-р улирал	их наяд ₮, оны үнээр	56.1	46.5	-	-	-	-	5.0% ▲
Инфляц	хувь	7.0	9.0	6.7	0.5% ▲	-	5.8% ▲	-2.0 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	5.8% 2024 оны У2	5.6% 2023 оны У2	-	-	0.7% ▲ нэгж хувиар	-	0.2 нэгж хувиар ▲
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1523	2062	1469	54 ▲	-	-	-538 ▼
Ам.долларын ханш	төгрөг	3392.00	3452.50	3380.95	11.5 ▲	-	-	-60.50 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	3627.4	4914.4	3174.4	453 ▲	-	-	-1287 ▼
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	65.9	59.1	52	-	-	-	13.9 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1357.9	1272	1186.4	-	-	-	85.9 ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	10%	13%	11%	-1%	-	0%	-3%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.7	3.9	4.3	0.83% ▲	-	-	18.2% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	5.82%	8.29%	5.63%	0.19 Нэгж хувиар ▲	-	-	-2.47 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

Ам.долларын ханш өсөж эхлэв.	Сүүлийн жилүүдэд тогтвортой байсан ам.долларын ханш 2024 оны 10-р сараас эхлэн өсөх хандлагатай байна. 2024 оны 10-р сарын байдлаар ам.долларын төгрөгтэй харьцах ханш 3392 болж өмнөх сараас 11.5 төгрөгөөр чангарав.
------------------------------	--

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны Төсвийн тухай хуульд бүхэлд нь хориг тавилаа	2024/11/20	2025 оны улсын төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай, төсөвт тодотгол хийх тухай тогтоол баталсан нь хууль дээдлэх үндсэн зарчим зөрчигдөх нөхцөл бүрдүүлсэн гэсэн хоёр үндэслэлээр бүхэлд нь хориг тавилаа.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Нөлөөлөл

Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 10 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 7.0 хувь, өмнөх оны эцсээс 5.8 хувь, өмнөх сараас 0.5 хувиар өссөн байна. 2024 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнсний барааны бүлгийн үнэ 7.6 хувиар, хүнсний бус барааны бүлгийн үнэ 6.8 хувиар, барааны бүлгийн үнэ 6.4 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 9.2 хувиар өсжээ.

Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 9 дугаар сард 3392.00 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 60.5 төгрөгөөр суларч, өмнөх сараас 11.5 төгрөгөөр чангарсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 0.83%-р, өнгөрсөн жилийн мөн үеэс 18.2%-р тус тус өсөж, 4.7 тэрбум ам.долларт хүрэв.

Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2024 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 25.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.7 (28.7%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 23.9 их наяд төгрөгт хүрч, 4.9 (25.9%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2024 оны эхний 10 сард 22.3 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.5 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2024 оны эхний 10 сард нийт 156 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 22.8 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 13.2 тэрбум ам.доллар, импорт 9.6 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 3.6 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.8 (13.8%) тэрбум ам.доллар, экспорт 732.7 (5.9%) сая ам.доллар, импорт 2.0 (26.8%) тэрбум ам.доллороор тус тус өсөж, тэнцэл 1.3 (26.3%) тэрбум ам.доллороор буурсан байна.

Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 10-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 10-р сар 2024 он, Монголбанк](#)
3. www.1212.mn, www.monqolbank.mn